

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2026 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ужиг Алтай Аудит ХХК-ны Захирал: Г.Ганболд
	Утас: 99117121 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЛТАНЦӨГЦ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
С.АВДИКАДИР ТАНАА

2026.02.25 № 172
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлох үйл явдал гараагүй байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

832805990136

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

ХОЁР .АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,226,602,400.00	3,051,335,064.21
УРСГАЛ ЗАРДАЛ	3,226,602,400.00	3,019,115,064.21
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,149,035,100.00	2,947,647,764.21
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,332,240,100.00	2,281,455,572.00
Үндсэн цалин	1,427,135,500.00	1,309,869,176.00
Нэмэгдэл	828,541,900.00	866,051,078.00
Унаа хоолны хөнгөлөлт		27,198,818.00
Урамшуулал	76,562,700.00	78,336,500.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,530,200.00	283,406,852.00
Тэтгэврийн даатгал	198,240,500.00	193,863,372.00
Тэтгэмжийн даатгал	23,322,500.00	22,389,900.00
ҮОМШӨ-ний даатгал	11,661,200.00	11,178,400.00
Ажилгүйдлийн даатгал	11,661,200.00	11,195,080.00
Эрүүл мэндийн даатгал	46,644,800.00	44,780,100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	289,549,000.00	214,430,875.00
Гэрэл, цахилгаан	13,567,000.00	13,069,475.00
Түлш, халаалт	275,982,000.00	201,361,400.00
Нормативт зардал	119,754,500.00	106,811,476.00
Хоол, хүнс	119,754,500.00	106,811,476.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,300,000.00
Урсгал засвар	2,000,000.00	1,300,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,010,800.00	19,557,239.21
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,010,800.00	19,557,239.21
Бараа үйлчилгээний бусад зардал	85,950,500.00	40,685,750.00
Бараа үйлчилгээний бусад зардал	76,168,400.00	31,485,750.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,782,100.00	9,200,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,567,300.00	71,467,300.00
Бусад урсгал шилжүүлэг	77,567,300.00	71,467,300.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,567,300.00	71,467,300.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	32,220,000.00
Дотоод эх үүсвэрээр	-	32,220,000.00
Тоног төхөөрөмж		31,800,000.00
Бусад хөрөнгө		420,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,970,524,475.00	2,970,524,475.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,754,758,600.00	2,754,758,600.00
Улсын төсвөөс санхүүжих	2,754,758,600.00	2,754,758,600.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	215,730,875.00	215,730,875.00

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн төсвөөс	215,730,875.00	215,730,875.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	35,000.00	35,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		127,308,526.38
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		46,497,937.17
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
Төсвийн байгууллага	1.00	1.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	81.00	82.00
Удирдах ажилтан	4.00	4.00
Гүйцэтгэх ажилтан	50.00	51.00
Үйлчлэх ажилтан	27.00	27.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	470.00	474.00
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	470.00	474.00
Төрийн өмчит ЕБС	470.00	474.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	81.0	82.0
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	50.00	50.00
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	2.00	2.00
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		1.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	28.00	28.00

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 291.5 сая төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад 291.5 сая төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсвөөс олгогдсон 291.5 сая төгрөгийн санхүүжилтийг орлого болон зардлын гүйцэтгэлд тусгалгүй тайлагнасан зөрчил илэрсэн. Энэ нь төсвийн гүйцэтгэлийг бодитой бус харагдуулах, орлого зардлын тэнцвэрт байдалд нөлөөлөх эрсдэл үүсгэж байсан тул уг дүнг орлого болон зардлын холбогдох ангилалд бүрэн тусган, тайлангийн мэдээллийг үнэн зөв болгох залруулгыг хийсэн.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал худалдан авах ажилгаатай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн байгуулсан бараа материал худалдан авах, нийлүүлэх гэрээнд гэрээний үнэ, нийлүүлэх барааны материалын тоо хэмжээ, үнийн дүн, нийлүүлэлтийн хугацаа тодорхой бус, төлбөрийн нөхцөл, зэргийг тодорхойгүй тусгаагүй зөрчилтэй байна.

Эдгээр нь санхүүгийн сахилга бат, ил тод байдал алдагдах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсгэж болзошгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах гэрээг байгуулж, гэрээнд бараа материалын тоо хэмжээ, нэгж үнэ, нийт дүнг тодорхой тусгах, нийлүүлэлтийн хугацаа, төлбөрийн нөхцөл, алданги болон хариуцлагын заалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тодорхой болгохыг зөвлөмж болгов.

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш **30 хоногийн дотор**, зөвлөмжийн биелэлтийг **2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөр** Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТайлан зөрүүтэй тайлагнасан	1	291,549.0	1	291,549.0			1	291,549.0				
Дүн	1	291,549.0	1	291,549.0			1	291,549.0				

Алтанцөгц сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээтэй холбоотой асуудал	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								